



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алдархаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/61/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2022 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор Б.Дагвасүрэн Утас:99014227 Цахим хаяг: dagvasurenb@audit.gov.mn</p> <p>Аудитор Ц.Оюунсүвд Утас: 99076038 Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

додд. од. д/д № 1302/19д

танай _____ -ны № _____ -т

АЛДАРХААН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ц.НАНДИНЦЭЦЭГ-Т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алдархаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алдархаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Audit(D)A4-тоот/2022

01302/192

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

ЭЗА	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>42,358,338.27</u>	<u>66,592,900.04</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	21.00	-
31110	Төгрөг	21.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	42,358,317.27	66,592,900.04
351	Түүхий эд материал	-	4,871,000.00
35130	Эм боох материал	-	4,871,000.00
354	Хангамжийн материал	42,358,317.27	61,721,900.04
35410	Бичиг хэргийн материал	812,000.00	1,069,200.00
35420	Аж ахуйн материал	1,502,500.00	3,889,300.00
35450	Барилгын засварын материал	4,429,500.00	3,885,000.00
35460	Хүнсний материал	5,364,712.00	6,147,110.00
35470	Бусад хангамжийн материал	30,249,605.27	46,731,290.04
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>576,394,773.82</u>	<u>724,742,491.55</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	576,394,773.82	724,742,491.55
392	Биет хөрөнгө	526,215,773.82	674,893,491.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	594,639,699.00	770,392,955.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(122,793,771.30)	(149,754,089.38)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,335,000.00	1,335,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,335,000.00)	(1,335,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	95,980,292.00	99,418,892.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(81,088,343.53)	(86,644,317.15)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,064,919.66	62,068,413.58
39208	Хуримтлагдсан элэгдэл	(31,951,408.22)	(37,297,076.11)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,551,943.00	3,551,943.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,756,897.39)	(1,882,312.99)
39217	Ном	14,569,340.60	15,039,083.60
393	Биет бус хөрөнгө	50,179,000.00	49,849,000.00
39301	Программ хангамж	2,600,000.00	2,600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,115,000.00)	(1,445,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	48,694,000.00	48,694,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>618,753,112.09</u>	<u>791,335,391.59</u>
413	Өглөг	8,256,016.00	17,704,780.58
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	8,256,016.00	17,648,780.58
4136	Бусад өглөг	-	56,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	56,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>610,497,096.10</u>	<u>773,630,611.02</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	610,497,096.10	773,630,611.02
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГ-ын сан/	445,813,001.30	445,813,001.30
51101	Өмч: - төрийн	445,813,001.30	445,813,001.30
512	Хуримтлагдсан үр дүн	(251,710,880.97)	113,145,372.95
51210	Өмнөх үеийн үр дүн	(251,710,880.97)	(49,988,141.97)
51220	Тайлант үеийн үр дүн	-	163,133,514.92
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	416,394,975.77	214,672,236.77
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>618,753,112.10</u>	<u>791,335,391.60</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	487,821,559.00	850,827,722.25
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,857,651.00	366,158,860.61
120	Нийтлэг татварын бус орлого	7,857,651.00	366,158,860.61
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,857,651.00	366,158,860.61
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	294,800.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,562,851.00	366,158,860.61
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	479,963,908.00	92,225,261.64
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	407,426,300.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	407,426,300.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	392,443,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,280,808.00	20,288,061.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,280,808.00	20,288,061.64
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	68,256,800.00	71,937,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /ОНТБ/	68,256,800.00	71,937,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	528,765,843.09	527,562,259.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	528,765,843.09	527,562,259.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	499,266,657.34	504,984,545.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	319,170,306.46	307,311,448.99
210101	Үндсэн цалин	319,170,306.46	179,847,996.99
210102	Нэмэгдэл	-	109,070,246.00
210104	Урамшуулал	-	18,393,206.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	40,077,122.79	40,321,499.28
210201	Тэтгэврийн даатгал	27,479,892.64	28,880,704.31
210202	Тэтгэмжийн даатгал	3,190,021.31	3,070,090.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,552,017.05	2,452,712.76
210204	Ажилгүйдлийн даатгал	623,199.25	537,999.18
210205	Эрүүл мэндийн даатгал	6,231,992.54	5,379,992.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,896,416.00	80,329,985.54
210301	Гэрэл, цахилгаан	2,832,713.00	3,356,567.94
210302	Түлш, халаалт	72,058,703.00	76,459,417.60
210303	Цэвэр, бохир ус	5,000.00	514,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,361,700.00	5,642,400.00
210401	Бичиг хэрэг	956,500.00	754,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,386,300.00	2,593,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	494,000.00	44,650.00
210404	Ном, хэвлэл	-	37,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,524,900.00	2,213,450.00
2105	Нормативд зардал	10,685,538.00	20,854,702.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,012,700.00	1,129,000.00
210502	Хоол, хүнс	9,498,338.00	17,939,402.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	174,500.00	1,786,300.00

Алдархаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	900,000.00	1,544,500.00
210604	Урсгал засвар	900,000.00	1,544,500.00
2107	Томилолт, зочны зардал	98,000.00	434,000.00
210702	Дотоод албан томилолт	98,000.00	434,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	315,593.00	864,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	278,700.00	864,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	36,893.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,761,981.09	47,682,010.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,118,100.00	2,500,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,643,881.09	45,181,110.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,499,185.75	22,577,713.41
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,522,208.00	19,897,478.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,741,400.00	5,374,100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,280,808.00	14,106,678.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	416,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,680,235.41
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,500,083.68
213304	Хөрөнгийн	-	1,180,151.73
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	21,976,977.75	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,976,977.75	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(40,944,284.09)	323,265,462.94
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	160,131,948.02
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	160,131,948.02
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(160,131,948.02)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(40,944,284.09)	163,133,514.92

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	ЗГ-ын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	445,813,001.30	416,394,975.77	(210,766,596.89)	651,441,380.18
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	445,813,001.30	416,394,975.77	(210,766,596.89)	651,441,380.18
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(40,944,284.09)	(40,944,284.09)
C08	2014 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	445,813,001.30	416,394,975.77	(251,710,880.97)	610,497,096.10
D01	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	445,813,001.30	416,394,975.77	(251,710,880.97)	610,497,096.10
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	201,722,739.00	201,722,739.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	445,813,001.30	416,394,975.77	(49,988,141.97)	812,219,835.10
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(201,722,739.00)	-	(201,722,739.00)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	163,133,514.92	163,133,514.92
D09	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	445,813,001.30	214,672,236.77	113,145,372.95	773,630,611.02

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	480,258,708.00	484,668,861.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	294,800.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	294,800.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	294,800.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	294,800.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	479,963,908.00	484,668,861.64
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	407,756,700.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	407,756,700.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	392,443,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,280,808.00	20,288,061.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,280,808.00	20,288,061.64
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,926,400.00	71,937,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,926,400.00	71,937,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	475,768,708.00	483,185,282.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	475,768,708.00	483,185,282.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	446,269,522.25	460,607,569.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	315,150,129.25	306,209,648.27
210101	Үндсэн цалин	193,819,848.00	178,746,196.27
210102	Нэмэгдэл	97,442,338.25	109,070,246.00
210104	Урамшуулал	23,887,943.00	18,393,206.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,097,300.00	41,423,300.00
210201	Тэтгэврийн даатгал	31,031,400.00	29,149,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,266,500.00	3,068,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,613,200.00	2,454,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	653,300.00	613,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,532,900.00	6,136,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,926,400.00	70,937,220.96
210301	Гэрэл, цахилгаан	2,832,713.00	3,356,567.94
210302	Түлш, халаалт	63,132,687.00	66,673,453.02
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	8,463,000.00	7,070,400.00
210401	Бичиг хэрэг	1,333,000.00	1,011,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,386,300.00	2,593,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	494,000.00	44,650.00
210404	Ном, хэвлэл	-	37,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	43,800.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,205,900.00	3,384,250.00
2105	Нормативд зардал	8,101,000.00	29,008,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,012,700.00	6,000,000.00
210502	Хоол, хүнс	6,913,800.00	18,721,800.00

Алдархаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	174,500.00	4,286,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,000,000.00
210604	Урсгал засвар	-	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	98,000.00	378,000.00
210702	Дотоод албан томилолт	98,000.00	378,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	315,593.00	864,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	278,700.00	864,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	36,893.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,118,100.00	3,716,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,118,100.00	3,716,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,499,185.75	22,577,713.41
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,522,208.00	19,897,478.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,741,400.00	5,374,100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,280,808.00	14,106,678.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	416,700.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	294,800.00	2,680,235.41
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	294,800.00	1,500,083.68
213304	Хөрөнгийн	-	1,180,151.73
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	21,682,177.75	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,682,177.75	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	4,490,000.00	1,483,579.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,530,000.00	1,483,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,530,000.00	1,483,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,530,000.00	1,483,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,530,000.00	1,483,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(4,530,000.00)	(1,483,600.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(40,000.00)	(21.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	40,021.00	21.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	21.00	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ЭЗА	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	464,929,300	463,200,669.23	1,728,630.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	464,929,300	463,200,669.23	1,728,630.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	458,435,000	457,409,869.23	1,025,130.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	307,261,200	306,209,648.27	1,051,551.73
210101	Үндсэн цалин	208,889,500	178,746,196.27	30,143,303.73
210102	Нэмэгдэл	81,713,200	109,070,246.00	(27,357,046.00)
210104	Урамшуулал	16,658,500	18,393,206.00	(1,734,706.00)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,480,200	41,423,300.00	56,900.00
210201	Тэтгэврийн даатгал	29,029,800	29,149,700.00	(119,900.00)
210202	Тэтгэмжийн даатгал	3,112,600	3,068,400.00	44,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,490,100	2,454,700.00	35,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	622,500	613,700.00	8,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,225,200	6,136,800.00	88,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,937,200	70,937,220.96	(20.96)
210301	Гэрэл, цахилгаан	5,961,600	3,356,567.94	2,605,032.06
210302	Түлш, халаалт	64,172,200	66,673,453.02	(2,501,253.02)
210303	Цэвэр, бохир ус	803,400	907,200.00	(103,800.00)
2104	Хангамж, бараа материалын зардал	5,745,100	6,738,200.00	(993,100.00)
210401	Бичиг хэрэг	280,600	679,000.00	(398,400.00)
210402	Тээвэр, шатахуун	3,686,300	2,593,300.00	1,093,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	500,000	44,650.00	455,350.00
210404	Ном, хэвлэл	421,000	37,000.00	384,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	857,200	3,384,250.00	(2,527,050.00)
2105	Нормативд зардал	29,008,100	29,008,100.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,000,000	6,000,000.00	-
210502	Хоол, хүнс	18,721,800	18,721,800.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,286,300	4,286,300.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000	1,000,000.00	-
210604	Урсгал засвар	1,000,000	1,000,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	392,900	378,000.00	14,900.00
210702	Дотоод албан томилолт	392,900	378,000.00	14,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	800,000	864,000.00	(64,000.00)
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000	864,000.00	(64,000.00)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,810,300	851,400.00	958,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,810,300	851,400.00	958,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,494,300	5,790,800.00	703,500.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,494,300	5,790,800.00	703,500.00

Алдархаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,994,300	5,374,100.00	620,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000	416,700.00	83,300.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	464,929,300	464,380,800.00	548,500.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	392,992,100	392,443,600.00	548,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	392,992,100	-	392,992,100
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	392,443,600.00	(392,443,600)
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	71,937,200	71,937,200.00	-
132001	Орон нутгийн төсвөөс	71,937,200	71,937,200.00	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	25	25	0
620001	Удирдах ажилтан	1	1	0
620002	Гүйцэтгэх ажилтан	16	19	-3
620003	Үйлчлэх ажилтан	8	5	3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,304,378.00	17,304,378.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,304,378.00	17,304,378.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,197,700.00	3,197,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	332,200.00	332,200.00
210401	Бичиг хэрэг	332,200.00	332,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,865,500.00	2,865,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,865,500.00	2,865,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,106,678.00	14,106,678.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,106,678.00	14,106,678.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,106,678.00	14,106,678.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,483,600.00	1,483,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,483,600.00	1,483,600.00
222001	Тоног төхөөрөмж	1,483,600.00	1,483,600.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	20,288,061.64	20,288,061.64
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,288,061.64	20,288,061.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,288,061.64	20,288,061.64

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Алдархаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Оюунсүвд гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа хэрэгжүүлсэн.

Алдархаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Алдархаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд "Сургах үйлийг дэмжиж, бие даан суралцах, эрүүл зөв хэвшмэл хүүхэд бэлтгэх" зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдсөн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алдархаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг нийт орлогоос 484.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 7.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 буюу 5.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мян.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	42,358.3	66,592.9	24,234.6
Үндсэн хөрөнгө	576,394.8	724,742.5	148,347.7
Нийт хөрөнгө	618,753.1	791,335.4	172,582.3
Өр төлбөр	8,256.0	17,704.8	9,448.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	610,497.1	773,630.6	163,133.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	618,753.1	791,335.4	172,582.3

Бараа материалын дансны үлдэгдэл 24,235.6 мянган төгрөгөөр өссөн нь түүхий эд материал 4,871.0 мянган төгрөгөөр, хангамжийн материал 19,363.6 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 148,347.7 мянган төгрөгөөр өссөн нь БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 9,428.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил олгосон, нэмэлт санхүүжилтээс 1,483.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдаж авсан, сумын ЗДТГ-аас 375,918.2 мянган төгрөгийн барилгыг балансаас баланст шилжүүлж авсан болон 200,164.9 мянган төгрөгийн барилгыг сумын ЗДТГ-т балансаас баланст шилжүүлсэн, мөн элэгдлийн зардал хасагдсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 163,133.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 464,929.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 464,929.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 392,443.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 71,937.2 мянган төгрөгийн, нийт 464,380.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 463,200.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны байгууллагаас 20,288.1 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг бүрдүүлсэн байна.

Нэмэлт орлогоос 3,197.7 мянган төгрөгийг урсгал зардалд, 14,106.7 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд, 1.483.5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Нягтлан бодогч нь зардлын эдийн засгийн ангиллыг гүйлгэн зарцуулсан, худалдан авалтын и-баримтыг бүрдүүлээгүй байна. Дотоод хяналтын нэгж үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын чанар, бараа материалын орлого, зарлагад тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 145 мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулж, хугацаа хоцорсон мэдээлэл 4 байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ хэсэгт 22,201.0 мянган төгрөгийн орлого, 38,202.6 мянган төгрөгийн зарлагыг, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 17,704.9 мянган төгрөгийн өрийг мэдээлээгүй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн “шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн

4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалттай нийцэхгүй байна” гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 0.9 сая төгрөгийн зөрчилд 1 заалт, шилэн данстай холбоотой 1 заалт, нийт 2 заалт бүхий зөвлөмж өгч, зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлд анхаарах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 117,903.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 30,887.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 6,877.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 заалт бүхий зөвлөмж, 2,030.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоож, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 78,108.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

25,261.8 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлийн аккруэл сууриар хөтлөөгүй болон мөнгөн гүйлгээний тайланд 5,625.6 мянган төгрөгийн, нийт 30,887.4 мянган төгрөгийн алдаанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Бусад хангамжийн материалын зардлаас албан хаагчдад ажлын дүрэмт хувцас бэлтгэхээр 1.786.3 мянган төгрөгийг “Энэрэл байгаль” ХХК-руу шилжүүлсэн, салбарын тэргүүн, жуух бичгээр шагнагдсан 2 багшид дагалдах мөнгөн шагнал 244.3 мянган төгрөгийг цалингийн зардлаас олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.4 “энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх”, 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 1.7 “төрийн албан хаагчид энэ журамд заасан мөнгөн шагналаас бусад шагнал олгоход мөнгө дагалдахгүй” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна.

4.3 Албан шаардлага хүргүүлээгүй

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

- ✓ 1,421.7 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай нийцэхгүй, ангилал, үнэлгээ ба хуваарилалт зэрэг батламж мэдээдлүүдийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ Батлагдсан төсвийг зарцуулахдаа Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг баримтлан ажиллаж, эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулахгүй байх;

2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

- ✓ 3,805.3 мянган төгрөгийн худалдан авалтын и-баримтыг бүрдүүлээгүй нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдээдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ"; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах;

3. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

- ✓ 2020 онд нийлүүлэгдсэн "Си-Ти-Эс" ХХК-ийн 1,650.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн программыг одоог хүртэл ашиглаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, УСНББОУС 17-той нийцэхгүй, тохиолдсон байх гэсэн батламж мэдээдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

- ✓ "Си-Ти-Эс" ХХК-аас нийлүүлэгдсэн 1,650.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн программыг 2022 оны 03 дугаар сарын 01-ээс ашиглаж эхлэх, 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг тус программаар гаргах

4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

4.1 Илрүүлэлт:

- ✓ Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ хэсэгт 22,201.0 мянган төгрөгийн орлого, 38,202.6 мянган төгрөгийн зарлагыг, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 17,704.9 мянган төгрөгийн өрийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3. "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 3.2.10. "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар", 3.2.11. "зээл, өрийн бичиг, баталгаа,

түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 10 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF форматаар” гэсэн заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

- ✓ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь хэсэгт санхүүжилт болон хоол, үдийн хоол, тэтгэмжийн зардал зэрэг 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй ажил гүйлгээг, 6.4.8 дахь хэсэгт төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг тухай бүр мэдээлж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая. төг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Алдархаан сумын Ерөнхий боловсролын сургууль	7	39.8	2	30.9	1	2.0			3	6.9
Дүн		7	39.8	2	30.9	1	2.0			3	6.9
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	Алдархаан сумын Ерөнхий боловсролын сургууль	1	78.1							1	78.1
Дүн		1	78.1							1	78.1
Нийт дүн		8	117.9	2	30.9	1	2.0			4	85.0